

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2012-01-24/**

Ажлын хэсгийн хуралдаан 2012 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр (Мягмар гариг)-ийн 16.00 цагт Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн 5 дугаар давхарын танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, Үндэсний зөвлөлийн гишүүн, ТАН эвслийн зохицуулагч, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, ажлын хэсгийн гишүүд Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дэлгэрбаяр, Миний Монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх захирал Б.Болдбаатар, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, Монголын байгаль орчны ТББ-ын холбооны иргэний зөвлөлийн гишүүн Б.Батболд, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн Д.Бүүвэйжаргал, Үндэсний татварын ерөнхий газрын улсын төсвийн орлого хяналтын газрын эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга Ч.Цэндмаа, ахлах байцаагч Энхтуяа, байцаагч Ч.Оюунчимэг, Ашигт малтмалын газрын мэдээлэл, судалгааны тасгийн дарга н.Бямбадагва, мэргэжилтэн С.Мөнхсайхан, Газрын тосны газрын хөрөнгө оруулалтын хяналтын тасгийн дарга Э.Оюун, Авилгатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан Ч.Сарангэрэл, Нүүрс ассоциацийн менежер Г.Сарангэрэл, Бороо гоулд ХХК-ийн мэргэжилтэн татварын нягтлан бодогч Г.Лхагва-Очир, Монголпросцветмет ХХК-ийн ерөнхий нябо Д.Номинзул, Монголын ажил олгогч эздийн холбооны мэргэжилтэн Д.Нанжидсамбуу нар оролцов. Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон хуралдаанд оролцогчдын ирц 70 хувьтай байгааг танилцуулав.

Хуралдаанд Гаалийн ерөнхий газрын мэргэжилтэн н.Булган, Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэргэжилтэн н.Дашзэвэг, Цөмийн энергийн газрын мэргэжилтэн Д.Наранцацral, Улаанбаатар Аудит корпорацийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, Мэндбаяр, Европын СБХБ-ны санхүүгийн ахлах ажилтан Пол Моффат, Европын СБХБ-ны санхүүгийн ахлах ажилтан Тосияки Сакацууме, Европын СБХБ-ны Европын СБХБ-ны санхүүжилтээр төсөл хэрэгжүүлж буй төслийн зөвлөх н.Чулуунбаатар, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Харилцаа, мэдээллийн мэргэжилтэн С.Батбаяр нар урилгаар оролцлоо.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж хэлэхдээ “Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар таван асуудал хэлэлцэнэ. **Нэгдүгээрт:** Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлан, **хоёрдугаарт:** Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны ажлын төлөвлөгөөний төсөл **гуравдугаарт:** Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлан, **дөрөвдүгээрт:** Монгол Улсын ОУИТБС-ын Ажлын албаны 2011 оны тайлан, **тавдугаарт:** Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох талаархи урьдчилсан тайлан зэрэг асуудлуудыг авч хэлэлцэнэ” гэв. Дараа нь

хурлын дотоод журмын төслийг танилцуулж, хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмын талаар гишүүдийн зөвшөөрлийг авснаар хуралдааныг эхлүүлэв.

### I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайлан

Улаанбаатар Аудит корпорацийн ахлах аудитор Н. Эрдэнэцог Монгол Улсын ОҮИТБС-ын 2010 оны нэгдсэн тайланг танилцуулав (танилцуулгыг хавсаргав).

**Б.Долгор:** За баярлалаа. Асуулт тавих хүн байна уу?

**Б.Долгор:** Зөрүү бол маш бага гарч ирсэн байна. Ялангуяа түрүүний урьдах тайлангуудтай харьцуулсан ч тэр, урьдчилсан тайлангийн байдлаар болон түүнээс хойш нэлээн ажил хийгдэж ер нь нийт зөрүү маш бага гарсан байна. Зөрүү бага гарсаны шалтгааныг юу гэж үзэж байгаа вэ?

**Б.Осоргарав:** Өмнөх 2009 оны тайлангаар бол 58,1 сая төгрөгийн зөрүү хамгийн суулд тайлбарлагдаж чадаагүй гэж үлдэж байсан. Энэ жил 356,000 төгрөгийн зөрүү үлдсэн. Уул уурхайн компаниуд, Засгийн газрын зүгээс Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Халамж, үйлчилгээний газар зэрэг тайлан авдаг байгууллагуудын ажил зүгширч ОҮИТБС гэж ийм том улсын хэмжээний ажил явагдаж байна, үүнд бас тодорхой хэмжээгээр ач холбогдол өгч оролцож ёстой юм байна, түүнд тодорхой хэмжээний мэдээлэл судалгааг нь үнэн зөв гаргах юм байна гэсэн хаанаа ойлгосон байдал бий болж байна. Үүний үр дүнд зөрүү багасч байна гэж бид нар ойлгож байна. Ер нь дэлхий нийтийн, олон улсын хэмжээнд зөрүү бараг гардаггүй, бүртгэл сайжирчихсан, мөн өгч байгаа нь, авч байгаа нь хоёр талдаа 5 төгрөг авсан ч, 10 төгрөг авсан ч үүнийгээ аль аль талдаа тусгаад явдаг практик байдаг. Энэ нь манайд анх удаа хийгдэж нэлээн зүгшрэх талдаа явагдаж байгаа учраас тодорхой хэмжээнд энэ ажил урагшилж байна, сайжирч байна гэж ойлгож байна. Үүний дээр зөрүү яагаад гарч ирээд байна вэ гэхлээр бол шинээр орж ирж байгаа компанийд дээр зөрүү үүсээд байна, яагаад гэвэл өмнө нь энэ ОҮИТБС-ын тайланд хамрагдаагүй байж байгаад шинээр орж ирсэн компани дээр бэрхшээл үүсч, тэдэнтэй ажиллахад хүндрэл гарч нөгөө компаниуд руу олон удаа хандаж маягт хүснэгт, энэ ажлын ач холбогдлыг ойлгуулах гэж ихээхэн цаг, хүн хүч хөдөлмөр зарцуулсан. Жишээ нь дараагийн 2011 оныход 200 компани яригдаж байгаа гэтэл 200 компани дотор чинь дахиад 50 компани шинээр нэмэгдэж орж ирж байгаа. Нэмэгдэж байгаа 50 компаний асуудал дахиад хүндрээд, тэдэнтэй энэ ажлаа ойлгуулах, нэгтгэл тайлангийн ач холбогдлыг ойлгуулах, өгсөн, авсан 2-ыг тулгаж шалгах, тайлагнах асуудал гээд тодорхой хэмжээний хүндрэлүүд гарч байна. Ажлын албанаас энд нэлээд ажлуудыг зохиож тодорхой хэмжээнд өнгөрсөн жил сургалтууд явуулсан. Үүний үр дүнд тодорхой ахиц дэвшил гарч энэ нэгтгэл тайлангаар цэвэр шийдэгдээгүй зөрүү багасч гарч байна. Манай компани бас практик дадлага, туршлага сууж байна.

**Б.Долгор:** Өөр санал хэлэх хүн байна уу?

**Э.Сумьяа:** Нэг санал хэлье. Бид тайланг өмнө нь хэлэлцсэн. Ажлын хэсгийн өмнөх хуралдааны дараа аудитын консорциум сайн ажиллажээ гэж нэгдүгээр хэлмээр байна. Хоёрдугаарт энэ тайланг хэвлэмэл байдлаар хүлээж аваад Үндэсний зөвлөлд оруулах саналтай байна. Засгийн газрын хүлээн авсан татвар, төлбөр компанийхаас их байгаа 11.8 сая төгрөгийн зөрүү нь компаниудын санхүүгийн бүртгэл дутуу байгаагийнх байх. Харин компанийнх нь Засгийн газрын хүлээн авснаас их байгаа байгаль хамгаалах зардлын урьдчилгаа 8.090. мянган төгрөг, мөнгөн хандив, дэмжлэг 3726.4 мянган төгрөгийн тулгалтын зөрүү үлдсэн байна. Тэдгээрийг тулгасан санхүүгийн баримтуудаа бидэнд өгөөч. Бид ажлын хэсгийн хэсгээсээ хүмүүс томилоод Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай ярьж байгаад байцаагчийн хамт явуулж шалгаж үзье.

**Б.Осоргаав:** Болно. Одоо угаасаа 11 компани дээр 356,000 төгрөгийн зөрүү байгаа.

**Э.Сумьяа:** Үгүй, үгүй. Тэр чинь биш, тайлангийн 2 дугаар хуудсанд хаалтан дотор байгаа 11 сая төгрөгийн зөрүүг хэлж байна. Засгийн газрын байгууллагууд хүлээгээд авчихсан, компани өгөөгүй гэдгийг бид нэг их сонирхогүй байна. Харин компани өгсөн гээд, Засгийн газрын байгууллагууд аваагүй гэсэн тэр баримтуудаа өгөөч.

**Н.Эрдэнэцог.** Энэ чинь Хан-Уул дүүргийн нөгөө хандивтай холбоотой

**Э.Сумьяа:** Томилолтын зардал багатай зүйлээс эхлээд үзмээр байна. Байцаагч бол олно. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүгээр нэг санхүүгийн байцаагч томилуулаад тэгээд өөрсдийнхөө ажлын хэсгээс төлөөлөгчийн "За та хэд нэг үзээд ирээч" гээд явуулах нэг ийм арга байна. Тиймээс баримтадаа өгөөрэй. Яг одоо гэхгүй, ажил чинь дуусаг, тайлангаа хэвлэх гэж байгаа болохоро. Миний гол санал бол энэ байна.

**Б.Долгор:** Өөр санал хэлэх хүн байна уу?

**Б.Батболд:** Одоо ингээд Үндэсний зөвлөлд оруулна гэж байна, тэгэхээр эцсийн байдлаар гэж ойлгож болох уу?

**Б.Долгор:** Тийм.

**Б.Батболд:** Одоо танай компани дахиад 2011 онд аудит хийх боломжгүй байх. Дараалан хэдэн удаа хийлээ. Шалгаруулалтанд орох боломжгүй байх гэж бодож байна. Гурван жил дараалан хийж байна. Ирэх жил боломжгүй, тийм үү?

**Б.Осоргаав:** Энэ тайлан бол зөвлөх үйлчилгээ. Цэвэр санхүүгийн тайлангийн аудитын тайланд бол хуулиар болохгүй. Хуулинд тэгээд заачихсан байгаа. Тийм учраас бид дараагийн шалгаруулалтад буюу 2011 оныход орох бүрэн эрхтэй.

**Б.Батболд:** Эцсийн зөвлөмж гэж гарахгүй юм уу?

**Б.Осоргарав:** Өмнөх хуралдаанд зөвлөмжөө оруулчихсан учраас өнөөдөр тэрнээс хойш ажилласан ажлаа ярьж байна. 12 дугаар сарын хуралдаанд зөвлөмжөө танилцуулсан байгаа.

**Б.Батболд:** Түүн дээр нөхөн сэргээлт дээр холбогдолтой асуудлууд гарч ирж байсан. Тэр бүгд орох уу

**Б.Осоргарав:** Бүгд орно. Том ном хэлбэртэй тайлан өгнө.

**Н.Баярсайхан:** Зөрүү гарсан найман төрлийн татварын хураамж байна. Үүнд компаний талаас шалтгаалсан компаний хариуцлагагүй дотоод төлбөр тооцооны зөрүү аль аль нь юм бэ гэж төрөлжүүлсэн байдалтай гаргавал зүгээр байна. Засгийн газраас шалтгаалсан, Засгийн газрын байгууллагууд аваагүй гээд компани төлсөн гээд байгаа гэх мэтчилэн ийм жаахан заагтай харуулвал зүгээр юм уу гэж харагдаж байна.

**Б.Долгор:** Тайланд өмнөх хуралдаанаар маш нарийвчлан хэлэлцсэн учраас хүмүүсийн санал оноо бага байх шиг байна. Түрүүний хурлаар хэлэлцэх үед гарсан саналуудыг нэлээн сайн тусгаж, зөрүүний шалтгаануудыг нарийвчлан гаргаж, зөрүү бага гаргасан байна. Тайланг гаргаж байгаа байгууллагууд маань сайн ажиллажээ гэж хэлж болохоор байна. Ингээд энэхүү тайланг Санаачлагын Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулъя гэж шийдэж байна. Хоёрдугаарт: хураангуй тайлангуудыг гаргах, нийтэд мэдээлэх, холбогдох газруудад хүргэх, тайлангийн мөрөөр цаашид анхаарах асуудлууд, засаж залруулах асуудлууд дээр анхаарч ажиллах, мөн олон нийтэд сурталчлах, хөдөө орон нутгийн иргэддээ хүргэж ажиллах, олон талт оролцогчдын бага хурал зохион байгуулах зэргээр тайлангийнхаа мөрөөр ажиллах арга хэмжээн дээр нэлээн анхаарч ажиллаж. Дээр нь Сумьяа гуайн хэлсэнчлэн Засгийн газрын байгууллагуудаас шалтгаалж байгаа асуудлууд дээр тодорхой хэмжээний шалгалт явуулах, зөрчлийн шалтгааныг нарийвчлан гаргах, үүний мөрөөр тодорхой арга хэмжээ авах, энэ ажил дээр анхаарч ажиллаж гэсэн ийм шийдвэрийг гаргаж байна. Энэ шийдвэр дээр санал, асуулт тавих хүн байна уу? За байхгүй бол эхнийхээ асуудлыг шийдвэрлэж дуусч байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгдсэн тайланг дэмжиж, Ажлын хэсгийн гишүүдийн хуралдаан дээр гаргасан саналыг тусган ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулахаар тогтов.

2. Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгдсэн тайланг үндэслэн улсын хэмжээний хураангуй тайлан, аймаг, нийслэл бүрээр хураангуй тайлан гаргаж, нийтэд мэдээлэх, холбогдох аймаг, нийслэлд хүргүүлэх, мөн хэвлэлийн бага хурал зохион байгуулж сурталчлах, олон талт оролцогчдын бага хурал зохион байгуулах зэрэг арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (Б.Долгор), Ажлын алба (зохицуулагч Ш.Цолмон)-т даалгав.

3. Тайлангаар Засгийн газрын байгууллагуудтай холбогдон гарсан 11 сая төгрөгийн зөрүүг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шалгахаар тогтов.

**II.ХЭЛЭЛЦСЭН нь:** Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны ажлын төлөвлөгөөний төсөл (Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа танилцуулав)

**Б.Долгор:** За асуулт байна уу.

**С.Мягмардаш:** Төлөвлөгөөний 2.7 дугаар заалт, мөн 30 дээр байгаа “Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөрийн орлого, түүний зарцуулалтын тайланг гаргаж төвд болон нийтэд мэдээлэх арга зүйн асуудал” гэсэн нь яг ямар агуулгатай юм бол?

**Э.Сумьяа:** Манай иргэний нийгмийн байгууллагуудаас 2 сумын тайлан гаргасан байгаа. Цаашдаа аймгийн дэд зөвлөл, аймгууд өөрсдөө тайлан гаргаж байя, зарим томоохон орлого бүхий уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж байгаа суманд тайлан гаргаж байя гээд ийм асуудал төлөвлөгдсөн байгаа. Түрүүчийн ажлын хэсгийн хурал, Үндэсний зөвлөлийн хуралдаан дээр гарсан санал юм. Тэгэхээр аймаг, сумын зөвлөлдөө арга зүйн зөвлөмж өгөх зорилгоор энэ арга зүйн асуудлыг боловсруулъя. Бид одоо таван тайлан гаргаад ажлын хэсгийн гишүүд ч ялгаагүй, үндэсний зөвлөлийн гишүүд ч ялгаагүй нэлээн сайн ойлголттой болсон байгаа. Яагаад гэвэл аудитын консорциум энэ тайлангуудын талаар бидний ойлголтыг улам нарийвчилсан байгаа. Орон нутгийн байгууллагууд тайлан гаргаж үзээгүй учраас ингэж ингэж ажилла гэдэг ийм арга зүйн зөвлөмж өгье гэсэн. Түүнийг л бичээд байгаа нь энэ. Ойлгогдож байна уу. Яг мөн чанар нь тэр. Тэгээд тэнд нь аймаг, нийслэлийн ажлын хэсэг гэсэн нэг юм байж байгаа.

**С.Мягмардаш:** Арга зүйгээ боловсруулна гэж ойлголоо. Боловсруулсан арга зүйгээ ажлын хэсгийн хурлаар хэлэлцэнэ гэхээр батлах шинжтэй юм болж байна уу?

**Э.Сумьяа:** Бид чинь олон талт оролцогчид. Тэгэхээр олон талт оролцогчдынхоо санаа бодлыг тэр арга зүйдээ тусгана гэсэн үг, тэрнээс биш батлахгүй.

**Д.Цэрэнжав:** ОҮИТБС-ын ажил орон нутаг уруу хүндийн төв нь шилжих шаардлага байгаа болов уу гэж ойлгож байна. Цаашдаа зөвхөн Улаанбаатар гээд яваад байхгүй байх. Тэгэхээр өнөөдрийн байдлаар аймгуудад ОҮИТБС-ын дэд зөвлөл хэдэн аймагт байгаа вэ? Ер нь байдал ямар байгаа вэ? Цаашдаа 2012 онд ажлынхаа төлөвлөгөөнд бүх аймагт дэд зөвлөлтэй болно гэдэг юм уу, эсхүл иймэрхүү байдлаар аймаг болгонд зорилго тавьж байгаа юм бий юу энэ талаар тодруулж өгөөч гэж хүсэх байна?

**Э.Сумьяа:** Нийслэлийг оролцуулаад 13 аймагт дэд зөвлөл байгаа. Шийдвэр нь манайд ирсэн байгаа. Манайх ийм бүрэлдэхүүнтэй гэх мэтээр. Дэд зөвлөл байгуулна гээд, төлөвлөгөөний Хоёрын 5, Долоогийн 59-д байгаа. Засгийн газрын тогтоолын төсөлд тодорхой заалт орсон, тогтоолын төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцээд одоо сайд нараас санал авахаар бэлдсэн байгаа, тогтоолд тодорхой

заагаад өгсөн. Аймаг ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг нь хүртэл тэр тогтоолын заалт болгоод заагаад өгсөн явж байгаа. Та бүхэн санаж байгаа бол энэ төслийг өнгөрсөн онд Ажлын хэсгийн хуралдаанаар 2 удаа хэлэлцсэн. ЕСБХБ-ны зөвлөмжийг хараад байсан юм, энэ нь өрөөсөө явахгүй байна. Одоо тэд нарын зөвлөмжийг хараад байвал бүр 2 жил хүлээх гээд байна. Тийм учраас тогтоолын төсөлд санал авах гэж байна.

**Д.Цэрэнжав:** Дутуу байгаа аймгуудад дэд зөвлөл байгуулах чиглэлээр явах уу? Цаанаас нь жам ёсоороо хүлээсхийгээд байх юм уу?

**Э.Сумьяа:** Нийтэд нь байгуулна. Одоо орон нутгийн сонгууль болсны дараа дахиад байгуулахгүй бол алга болчихно.

**Б.Батболд:** Модуль сургалт гээд энд байж байна. Урд нь явуулж байсан сургалтын хөтөлбөр юм уу, эсхүл шинээр боловсруулаад гаргах юм уу?

**Э.Сумьяа:** ЕСБХБ-ны төсөл хэрэгжиж байгаа. Тэрний нэг хэсэг нь сургалтын хөтөлбөр байгаа, чадавхи бэхжүүлэх сургалтын материал бэлтгэж байгаа. Тэгэхээр төслийн зөвлөх Эмма гээд хүн бидэнтэй өнгөрсөн 12 дугаар сард уулзсан, та бүхэн ихэнх нь таньж байгаа байх. Бид уг нь өөрсдийнхөө хүчээр сургалтын модуль боловсруулъя гэж төлөвлөж байсан. Гэтэл боловсруулах чадавхи бид нарт арай хүрэхгүй юм шиг байхаар нь тэр төслийн бүлэгт боловсруулж өг гэж шахалт үзүүлсээр байгаад боловсруулахаар оруулсан байгаа. Энэ нь юу вэ гэхээр сургалтын хэд хэдэн хөтөлбөрийн загвар гарна гэж бид ойлгож байгаа. Энд зорилтолт бүлэгтэй, анх удаа тайлан гаргахад ямар загвараар сургалт явуулах, алдаатай тайлан гаргадаг аж ахуйн нэгжид ямар загвараар сургалт явуулах, төсвийн байгууллагад ямар загвараар сургалт явуулах, давтан сургалтыг ямар хөтөлбөр загвараар явуулах, сургалтын агуулгууд нь ямар байх вэ? гэх мэтээр зорилтолт бүлгээ сонгохоос эхлээд сургалтын үр дүнгээ хүртэл төлөвлөсөн тийм л. материал хүлээж авна гэж бид үзэж байгаа. Өчигдөр хүртэл ЕСБХБ-ны ажилтан Пол-той уулзахдаа энэ талаар дахин хэлсэн байгаа. Хүлээж авч, тэгье гэсэн. Өөрөөр хэлбэл тэндээс анхны төсөл нь гарч ирэх юм. Бид мэдээж өөрсдөө бас суугаад арай боловсронгуй болгож таарна. Тэгэхдээ гурван талынхаа оролцоог хангаж энэ материал дээр сууж ажиллана.

**Н.Баярсайхан:** Энэ нийт төлөвлөсөн 75 ажлын бараг 30 гаруй хувь нь зардлын эх үүсвэргүй юм байна. Эх үүсвэргүй юм чинь ажил хэрэг болж чадах болов уу гэж асуумаар байна? 6 дугаар бүлэгт чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулна гэж байна. Энэ дээр бүх талыг, 3 талыг бүгдийг нь чадавхижуулвал зүгээр. Иргэний нийгмийнхэн орон нутгийн түвшинд илүү санаачлагатай ажиллаж гэж ярьж байгаа. Энэ талаасаа илүү оруулж болохгүй байсан юм уу?

**Э.Сумьяа:** Зардлын хувьд энд төрийн байгууллагуудын нэр байгаа. Бид Засгийн газрын байгууллагынхаа авч байгаа цалингаар энд ажиллана гэсэн үг. Тийм учраас тавиагүй ээ. Ер нь анхнаасаа оролцогч талууд өөрсдийн зардлаар хийдэг олон ажил бий. Хоёрдугаарт: та Үндэсний зөвлөлийн хуралдаан дээр ТББ-н

чадавхийг бэхжүүлэх талаар асуудлыг оруулаач ээ гэж бас санал гаргаж байсан. Дэлхий Банктай бидний тохирсон нэг зүйл байгаа юм. Иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлнэ гээд 9 дүгээр сард Дэлхийн банкнаас нэг семинар хийсэн. Тэгээд төрийн бус байгууллагын сургалтын хэрэгцээг нь 3 бүлэг болгоод тодорхойлсон. Цолмон бид 2 ерөнхий хичээлд нь ороод сургалтын хэрэгцээ тодорхойлоход нь ороогүй. Дэлхийн банкны зөвлөх Энхзаяа удирдаад, Алгаа, Дорждарь, Цолмон оролцсон. Сургагч багш тусад нь томилуулаад тэгээд сургалтын хэрэгцээг нь тодорхойлсон. Энэ сургалтад Дэлхийн банк тодорхой хэмжээний мөнгө гаргах гэж байгаа юм. Тэгэхээр иргэний нийгмийн байгууллагуудыг тэрүүгээр чадавхижуулна гэж уг нь тохирчоод явж байгаа юм. Чадавхи бэхжүүлэх, харилцааны ажилтан гэдэг дээр бүх талуудаас нэг нэг хүн сургана гэж оруулсан байгаа. Энд Батбаяр байгаа. Эндээс сургагч багш нарыг оролцогч талуудаасаа харилцааны чиглэлээр бэлдэж авах юм. Тийм учраас та бүхэн Батбаярт тодорхой хүний нэр өгөөрэй. Ассоциаци байна, иргэний нийгмийн ТАН эвсэл байна, ТЕГ, АМГ гэх мэтээр орон тоогоор ажиллаж байгаа хүмүүсээ сургаад авах гэж байгаа. Хэрэв Дэлхийн банкных бүтэхгүй бол бидэнд бас дараа нь Дэлхийн банкны 12 сургалт байгаа, энэ жил 3-ийг явуулна, 9-ийг нөөцлөөд байгаа, тэндээсээ ч гэсэн нэг сургалт явуулна. Гэхдээ энэ жил арай багтахгүй байгаа. ЕСБХБ-ны 12 удаагийн сургалтыг энэ жил багтаачих санаатай байна. Энэ онд 15 сургалт явуулах чиглэлтэй байна.

**Д.Наранцацral:** Төлөвлөгөөний 45 дээр “ОҮИТБС-ын Засгийн газрын тайланг цахим хэлбэрээр хүлээн авах программ хангамж бий болгох” гэсэн байна. Энэ дээр програм зохиох юм уу, эсхүл электрон хэлбэрээр тайлангаа авах юм уу?

**Э.Сумьяа:** Програм зохионо. ТЕГ-т бага зэргийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэхээр явж байгаа ч, мөнгө нь хүрэхгүй байгаа. Өчигдөр манайхыг хариуцсан Дэлхийн банкны зөвлөх Энхзаяа хэлэхдээ “GTZ” гээд Германы төслийн шугамаар манайд програм хангамжийг зохиох чиглэлээр дэмжлэг үзүүлье гэсэн зүйл яригдаж байгаа юм байна. Яг энэ манай тайлан гаргадаг дээр. Тийм учраас би өөрийн саналаа хэлсэн. “Та бүхэн компаний тайлан гаргадаг нэг программ хангамж тусдаа гаргана, ТЕГ-ынх дээр түшиглэнэ шүү” гэж Энхзаяад хэлсэн л дээ. Мөн компанийн тайлан гаргадаг программ хангамж нь 2 дахь чиглэлээр явна шүү, санал болгож байгаарай гэсэн. Танай ТЕГ-ын 20 сая төгрөг ноднин ярьж байгаад хүрээгүй. Тэндээрт оролцох хүн байгаагүй. Татварын байгууллагад ийм програмтай болчих юм бол энэ жил юмуу ирэх жилээс ч юм уу тодорхой хэмжээний сургалт явуулж байгаад орно гэсэн уг.

**Оюун:** Төлөвлөгөөний 2.8 дээр Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажиллах чиглэл орсон байна. Бүтээгдэхүүн хуваах бүх байгуулсан гэрээнүүдийг бүгдийг нь ил болгоё гэж байгаа юм уу, тодорхой хэсгийг нь ил болгоё гэж байгаа юм уу, загвар гэрээг ил болгоё гэж байгаа юм уу, энэ ер нь ямар чиглэлээр авсан юм бол?

**Э.Сумьяа:** Оюун бид 2 өмнө нь нэлээн олон удаа ярилцсан асуудал байна. Нэгэнт бүтээгдэхүүн хуваах гэрээ байгууллагын нууцын гэрээнд явж байгаа. Гэхдээ бид нар, хоёулаа тэмцсээр байгаад, чиний хүчин чармайлтыг мэднэ, компаниуд

тайлангаа гаргаж байгаа. Яг гэрээг ил болгох гэхээр бас нэг зовлон байгаа. Өөрөөр хэлбэл, түрүүчийн гэрээнүүд, хүчингүй болсон гэрээнүүд Америкийн нэг сайт дээр зарагдаж байсан. Газрын тосны тухай манай хуучин хууль 800 доллар, тэр гэрээ мөн 800 доллараар тэр үед зарагдаж байсан. Тэгэхээр энд нэг ийм 2 талын зовлон байгаа. Танай иргэний нийгмийнхэн ч энийг үзсэн. Нээгээд ил болгох нэг хэцүү, эсхүл нууцлаад байхаар бидэнд бас нэг хэцүү. Тийм учраас тодорхой юмыг та нар яриад ийм хэсгийг нь ил болгоё өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн хуваах, одоо нэг ялгавар байгаа, анхных нь болохоор 40x60 харьцаатай байсныг нуусны хүчинд хамгийн эцсийн бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд Засгийн газарт 60, компанийд 40 болчison. Өөрөөр хэлбэл энэ нуусны хүч байгаа юм. Хэрвээ хаалттай байгаагүй бол барьцаад л цаадуул чинь тэдэн хувьтай байна гээд ахиц гарахгүй байх гэж би ойлгодог юм. Засгийн газрын тогтоолоор авах төлбөрүүдийг тогтоосон байгаа. Тийм учраас тогтоолд байгаа төлбөрийг нуух ч юм байхгүй. Тийм учраас энийг нээлттэй болгохын тулд чи саналаа аваад ир, тэгээд бид ажиллана.

**Б.Долгор:** Бүсүүдийн чуулга уулзалт, сургалт гэж байна, үүнийг бүс болгонд явуулах шаардлагатай юу? Миний бodoход гол газрууддаа илүү анхаарал хандуулвал ясан юм бэ. Нарийндаа ганц бүс нутаг л байгаа. Үүнд илүү анхаарал хандуулж, зорилтот байдлаар ажиллах юм биш үү гэж бодогоод байна. Ерөнхийдөө энэ ажил хүч тарамдсан маягтай байгаад байна. Үүн дээр ер нь ямар санал байна?

**Э.Сумьяа:** Үүнийг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталсан 2 жилийн ажлын чиглэлдээ оруулсан байгаа. Чиглэлд тусгасан байдлаар нь авсан. Ажлын хэсгийн хурлаар шийдээд тэр аймаг дээр гол хүчээ гаргая гээд шийдвэл зохицуулж болно. Зарим аймаг дээр арай цөөн бүрэлдэхүүнтэй очиж ажиллах байх. Өмнө нь бүсийн уулзалт Ганболдыг байх үед Дорждарь, Алгаа нар их эрчимтэй хамтарч ажиллаж байсан. Бид Ерөнхий сайдын илгээлт, мэндчилгээ явуулж байв.

**Б.Долгор:** Асуулт дуусч байна уу, саналаа хэлцгээх үү

**Н.Алгаа:** Түрүүн ярьж байсан. Яг орон нутагт мэдээлэл хүргэх асуудал хангалтгүй байгаа, үнэхээр хүргэж чадахгүй байна. Хүч гаргах хэрэгсэл, боломж гээд бүх юм дутагдаад байна. Бүсийн зөвлөлгөөн, орон нутагт байх дэд зөвлөлийн тухайд Долгор даргатай санал нэг байна. Кампанит ажил шиг хавтгайруулаад үр дүнгүй юм хийж байсанд орвол Өмнөговь шиг том бүс аймагт, бас Сэлэнгэ аймагт тодорхой сүмд тойрсон жижиг бүсүүд байна. Тэр бол манай Монголын халуун цэг болж байгаа. Тэр хэсгийг уул уурхайн хувьд бүс гэж үзээд ОУИТБС-д оруулахаас биш засаг захиргааны хувиар явбал үр дүнгүй болдог. Энэ талаар байгаль орчны хяналт дээр ч гэсэн урд нь зөндөө хэлдэг байсан. Аймаг болгонд, сум болгонд нэг нэг хүнтэй байж байхын оронд илүү түлхүү хөгжиж байгаа газарт нь төсвийг нэмээд 2-3 хүнтэй болгоод мэргэшүүлж, бид байгаль орчны хамгааллын мониторинг хяналт хийхгүй бол болохгүй. Тэрэнтэй адилхан зарчмаар эхний ээлжинд жишээ нь Өмнөговь аймаг, Ханбогд, Цогтцэций, Сэлэнгэ аймаг гэхэд Хүдэрээр, Төв аймагт гэхэд Заамар гээд хийж болно. Ховдод гэхэд ганц Хөшөөт гэх мэт. Тэрнээс биш Улаангомд очиж бүсийн чуулган хийгээд яах вэ дээ. Зүүн бүс гэхэд Дорнод байна,

уран, полиметаллын ордуудтай, хайгуулын лицензээр бус, харин ашиглалт явагдаж байгаа тэр хэсгийн сум, аймаг гэж бүчсилсэн нь дээр гэсэн санал байна. Хоёрдугаарт, бүр том зарчмын санал байна. Ажлын төлөвлөгөөг уншихаар үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын алба ороод нэг их том төлөвлөгөө, 75 арга хэмжээтэй. Дараа нь ажлын албаны 35 ороод ингээд 100 гаруй арга хэмжээтэй. Энэ зовлонг уул уурхайн ассоциациад жил болгон ажлын төлөвлөгөө хийж 140-150 гишүүдэд танилцуулдаг би мэднэ. Санал өгөхөд хэцүү, эсхүл хэтэрхий задгай учир хэтэрхий жижиг санал яваад байдаг. Тэгэхээр ямар санал тавьж байна вэ гэхлээр 2013 онд 3 талт ажлын хэсгээс төлөөлөл гаргаад, нэг өдөр нэг газар суугаад бидэнд ямар давуу тал байна, бидэнд ямар сул тал байна, бидэнд ямар боломж байна, ямар сул тал нь бидэнд ямар эрсдэл бий болгож байна гээд орчин үеийн шинжилгээний арга байна, тэрүүгээр яваад бид манай энэ ОҮИТБС-ын цаана зөвхөн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ гэсэн ийм хэлбэрт оруулж нийтийн хүртээл болгож, төсөв санхүүтэй, гарах үр дүнг хэмжих бололцоотой, ийм байдлаар төлөвлөвөл арван хэдэн ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн том зорилт гарч ирнэ. Тийм хоёр зарчмын санал байна. Одоо энэ санаачлагын ажлын төлөвлөгөө, ажлын албаны төлөвлөгөөг батлаад хэрэгжилтэнд нь мониторинг хийгээд үзнэ биз. Тийм л санал байна. Тэрнээс биш 75-ууланг нь ярилцаад хэлэлцэнэ гэдэг хэцүү. Цаг хугацаа ч байхгүй.

**Болдбаатар:** Надад бас санал байна. Бус нутгаар хуваахаас илүүтэй, ашигт малтмалынх нь төрөл ангиллаар хувааж болох юм байна. Алт, нүурс гээд л, газрын тос, төмөр гээд явчихаж болно. Тэгвэл эд нар чинь нэг газартаа төвлөрөхдөө амархан. Хамгийн тулхүү хөгжиж байгаа жишээ нь төмөр гэхэд болд төмөр гэдэг ч юм уу, зэс молибдени гээд Оюутолгойд орчихно. Яг тэр газар дээр нь төвлөрүүлээд тэр газарт нь хамтраад явбал илүү үр бүтээлтэй байх болов уу гэж бодогдоод байна. Газрын тос гэхэд Тамсаг дээр гэх мэт.

**Н.Алгаа:** Тэр бус чинь миний түрүүний хэлдэгтэй бараг давхцах гээд байна.

**Э. Сумьяа:** Гурван бүтээгдэхүүний зардал байгаа.

**Н.Алгаа:** Тэгэхээр гурван газар сонгож хийнэ гэж байгаа юм байна.

**Э.Сумьяа:** Та нар саналаа хэлчих. Би гурван газар сонгоод тавьлаа. Нэгийг нь Засгийн газрын байгууллага ахлаад хийе, нэгийг нь иргэний нийгмийн байгууллагууд ахлаад хийе, нөгөөг нь компани хийе.

**Н.Алгаа:** Болдбаатарын саналтай нэг байна. Өмнөговь дээр Оюутолгойг зэсээр тэр Эрдэнэт энэ тэр гээд нүүрсээр, төмрөөр хийе.

**Э.Сумьяа:** Нүүрсээр нэг уулзалтаяа хийе гэж үү.

**Н.Алгаа:** Нүүрс, зэсээр, тэгээд төмрөөр гурван бүтээгдэхүүн болж байгаа биз.

**Б.Долгор:** Нүурс, зэсийг хамтруулж болно. Төмрөөрөө нэг хийгээд, алтаараа нэг хийж болох юм.

**Н.Баярсайхан:** Сумьяа гуай та анх төлөвлөхдөө аймаг болгон дээр хийнэ гэж төлөвлөөгүй биз дээ.

**Э.Сумьяа:** Үгүй үгүй, бусээр хийсэн. Дэлхийн банкнаас санхүүжилт авахын тулд ингэж төлөвлөсөн юм.

**Б.Батболд:** Бүсчилж хийгээд уурхай дээр зохион байгуулаад эд нарын зорилго нь яг юу байх вэ?

**Ш.Цолмон:** Эрдэс баялаг, ашигт малтмалын төрөл гэхээс илүү бүсчилсэн нутгаар явъя гэж байгаа юм. Жишээ нь өмнө нь Өвөрхангай аймагт зохион байгуулсан, энд Баянхонгор, Архангай, Төв, Булганыхан ирж байсан, З тал оролцсон. Бүсчилсэн уулзалтын гол чиглэл нь ил тод байдал байх ёстой гэж нэг хэсгийг яриад, орон нутгийн чанартай асуудлыг Засаг дарга, бус нутгийн иргэний байгууллагууд, бус нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд гээд ингээд З талаасаа ярьж нэлээн халуун маргаан өрнүүлж байсан. Жишээ нь Сэлэнгэ аймагт нэлээн маргаан, хэлэлцүүлэг болсон. Сэлэнгэд Орхон, Булган, Хэнтий ойр хавийнхан нь ирж байсан. хамгийн гол нь тийм харилцан яриа, зөвшилцэл, зөвлөлгөөн явуулж байсан. Энэ байдлаар явуулъя гэсэн чиглэлээр бид энэ ажлын төлөвлөгөөг хийсэн. Хамгийн гол нь орон нутагт болж бүтэхгүй байгаа юмыг харилцан ярилцъя, ОҮИТБС гэж юу байдгийг сурч авъя, Засаг дарга, компани, иргэний нийгэм энд яж оролцох, хяналт тавих гэх мэт ийм сургалтын чанартай.

**Н.Баярсайхан:** Өмнөговь аймагт бүсчилж хийхэд Өмнөговь аймгийн хэмжээнд л 2 талын тайлан гарсан талаар бид нар хэлэлцүүлэг хийсэн. Талууд саналаа хэлээд л “Бид нар аймагтаа очиж ийм юм хийж болох юм байна” гэх мэт Жишээ нь Дундговийн салбар зөвлөл, иргэний нийгмийнхэнтэйгээ хамт өнгөрсөн жил ирж оролцоод туршлага судлаад явж байсан.

**С.Мягмардаш:** Бүсчилж зохион байгуулна гэдэг дээр би дэмжиж байна. Өмнөх туршлагаас харахад зохион байгуулж буй сургалт ч бай, семинар ч бай энэ нь олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд рүүгээ хандчихдаг. Тухайн бүсэд очсон ч гэсэн бас тэр бус нутгийн орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг оролцуулж, илүү дутуу зөрүү гаргаад байгаа баримттай, баримтгүй юм гаргаад байгаа жишээг, нотолгоог тэнд гаргаж тавьж, орон нутгийнхан та нарт тайлангаа гаргахдаа ийм ийм алдаа гаргаад байна, аж ахуйн нэгжүүд өгсөн баримтад гаргаж ирж байхад танай сумын Засаг даргын Тамгын газар чинь ийм юм аваагүй гээд ирүүлсэн гээд түрүүний Осоргарав гуайн хэлдэг жишээнүүдийг гаргаж ирээд хийвэл Санаачлагын тайлангийн маань баталгаажуулалтын үр дүн дээшлэх, цаашилбал олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн удирдлагаас гадна орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын тайлан гаргадаг тэр хүмүүсийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэх ёстой ойлгож байна.

**Д.Цэрэнжав:** Энэ тайлан Үндэсний зөвлөлөөр ороод олон нийтэд зарлагдана. Манай улс 5 тайлантай боллоо. Олон жил ажиллалаа, маш их ажил боллоо, зардал чирэгдэл их гарлаа, энийгээ одоо яаж ашиглах вэ гэдэг тал дээр энэ онд эргэлт гаргах нь зүйтэй юм шиг байна. Таван тайлангаа эргэж үзээд нэг ийм бүтээгдэхүүн гаргаж гаргамаар байна. Ажлын албанаас зохион байгуулаад ч юм уу, яаралтай 5 дахь тайлан гарангут өмнөх тайлангуудтайгаа нийлүүлээд энэ тайлан гаргах ажилд хар данс маягийн, эсхүл сайн данс маягийн юм гаргаж ирмээр байна. Ийм компани жил болгон сайн оролцдог, ийм компани жил болгон дандаа хоцордог, удаадаг гэх мэт. Үүнтэй нэгэн адилаар төрийн байгууллагууд, Засаг даргын Тамгын газрууд ч гэж үзэе. Энэ бүх материалыа ашиглаад нөлөөллийн гарын авлага болохуйц, бүтээгдэхүүн болохуйц ийм юм хийгээд гаргах хэрэгтэй байна. Хар данс энэ тэр дээр нэг ойлголт байдаг, жагсаачихаад тэр дандаа буруу зөрүү хийсэн учраас ичээж байна гэдэг шүү дээ. Ийм баримттай, бүтээгдэхүүнтэй болж байгаад үүнээ ашиглаад орон нутагт нь тэр зөвлөлгөөнүүд зохион байгуулмаар байна. Яам, тамгын газруудтай бид ажилламаар байна. Таван тайлангаа ашиглаад ямар компани жилээс жилд дутагдлаа давтаж байна, засаж байна, ийм материалтай болоод энэ дээрээ түшиглээд дараачийн ажлуудаа хийвэл их зүгээр юм бол уу гэж санагдаж байна.

**Б.Батболд:** Дэлхийн банкны чиглэлээр ОУИТБС-ыг орон нутагт мэдээлэл хүргэж байх төв байгуулах маягийн юм яригдаад өнгөрсөн. Ер нь бол боломжийн бас нэг жаахан юм гаргачихмаар байна. Үүнтэй хамтарч ажиллах энийг хийх талаар ажлын төлөвлөгөөнд холбогдолтой юм байхгүй байгаа. Энэ больчихсон юм уу.

**Ш.Цолмон:** Энэ ажил тодорхойгүй байгаа юм. Тусlamжаа үзүүлэх Дэлхийн банкнаас хэнтэй, хэнд олгох вэ, төслийг хэн хариуцах гэдэг дээр маргаантай байгаа. ТАН эвсэлтэй шууд хамтрах уу, эсхүл шууд байгаль орчинтой холбогдох уу зэрэг нь ойлгомжгүй, хүлээгдээд байгаа гэж ойлгож байгаа.

**Э.Сумьяа:** 2, 3-н санал гарлаа. Би төлөвлөгөөнд тусганаа. За бүсчилсэн гэдэг дээрээ тогтсон уу Цэрэнжавын бүтээгдэхүүн гэдгийг хавсралт тайлан дээр оруулъя. Гуравдугаар санал болох 2.4 дээр иргэний нийгмээр гол ерөнхий арга зүйгээ боловсруулъя. Батболд бас БОАЖЯ-ыг энд оруулъя.

**Б.Долгор:** Төлөвлөгөөний төслөө дэмжээд энэ хүмүүсийн гаргасан саналуудыг тусгаад баталъя гэсэн саналтай байна. Хүмүүсийн гаргасан санал бол зөв зүйтэй санал байна. Цэрэнжав гуайн гаргасан санал, бас би өөрийнхөө гаргасан саналыг чухал гэж үзэж байгаа. Ер нь хамгийн гол төвлөрсөн газрууд дээрээ илүү төвлөрүүлж явуулах нь зүйтэй, түүнээс биш ерөөсөө тайланг гаргах нь ач холбогдолгүй газрууд байна. Тийм учраас яг бүсчилсэн гэдэг утгаараа биш түрүүний дурьдсан гол гол газрууд дээрээ төвлөрөөд оролцуулах ёстой хүмүүс, талуудаа бүрэн оролцуулаад, тодорхой газруудад, оролцогч талуудад ач холбогдолтой байхуйцаар, тэднийг оролцуулах замаар ингэж хийе гэсэн саналыг тусгаад төлөвлөгөөгөө баталъя гэсэн саналтай байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар ажиллах асуудлаар даалгавар өгөгдөж байна. Алгаа гуайн түрүүн гаргасан зарчмын

санал байгаа. Тэр маш чухал санал юм. Ерөнхийдөө төлөвлөгөө хийдэг арга барил бас жаахан өөрчлөгдөөд байгаа. Ялангуяа шалгуур үзүүлэлт. Тэгээд үр дүнг нь тооцох гэдэг маягаар явах ёстой. Энэ тал уруу ерөнхийдөө орох нь зүйтэй байна. Ажлын албаныхан, Сумьяа гуй үүнийг анхаараад ямар нэг хэмжээгээр тийм байдлаар гаргахын тулд Алгаа гуйн хэлсэнчлэн нэг тодорхой хүмүүсийг суулгаад хийвэл зүгээр болов уу гэж бодож байна. Тэр зүйтэй байх. За ингээд төлөвлөгөөгөө батлав.

**ШИЙДВЭРЛЭСЭН** нь: 1. Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны төлөвлөгөөний төслийг дэмжиж, Ажлын хэсгийн гишүүдийн хуралдаан дээр гаргасан саналыг тусган Үндэсний зөвлөлөөс Ажлын хэсэгт олгосон эрхийн дагуу батлав.

2. Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны төлөвлөгөөний заалт бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарт даалгав.

**III, IV. ХЭЛЭЛЦСЭН** нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2011 оны тайлан, Монгол Улсын ОҮИТБС-ын Ажлын албаны 2011 оны тайлан (Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав)

**Б.Долгор:** Асуулт тавих хүн байна уу?

За байхгүй бол санал хэлэх хүн байна уу?

**Н.Алгаа:** Ажлын алба саяхан харилцаа, мэдээллийн хүнтэй болж байна. Хоёр хүнтэй ажлын алба их сайн ажилласан гэж та бүгдийн нэрийн өмнөөс энэ хүмүүст талархал илэрхийлмээр байна. Нэгэнт хийсэн ажилд нь бид тэр ажлын хэсэгт ороод хийсэн ажил болгонд оролцож байсны хувьд Ажлын албаны ажилд миний зүгээс манай салбарын болон компаниудын зүгээс сэтгэл хангалаун байгаа гэж бодож байна. Тийм учраас хэрэв үнэлэлт дүгнэлт өгдөг бол хангалттай сайн ажилласан гэсэн тийм үнэлэлт өгч байна.

**Э.Сумьяа:** Монгол Улсын ОҮИТБС-ын 2011 оны тайлангийн агуулга гээд тараачихсан байгаа, та бүхэн энэ дээр одоо санал гаргахгүй байж болно. Энэ тайлан бол 7 дугаар сар гэхэд Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газарт явах ёстой. Та бүхэн энэ дээр нэмэх зүйл, дутуу зүйлийн талаар саналаа өгнө үү. Саналаа е-мэйлээр өгөөрэй. Цаашид бид тайлан дээр сууна, шинэчилсэн дурмийн дагуу зарим хийгдэж байгаа зүйлийг нэмэх юм бий. Тийм болохоор та бүхэн саналаа Цолмонд е-мэйлээр явуулаарай. Дараа нь эцсийн шатны тайланг Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газар уруу яг явуулахын өмнө оролцогч гурван талынхаа багийн ахлагч нар ТАН эвслийн зохицуулагч, Ассоциацийн гүйцэтгэх захирал, Сангийн яам, Эрдэс, баялаг, эрчим хүчний яамны төлөөлөлд уншуулж танилцуулна. Тийм учраас та бүхэн саналаа бичиж өгөөрэй. Одоо хэлэх зүйл, санал

байвал их сайн байна. Тэгвэл агуулга нь баяжиж магадгүй зарим бүлгийг ч өөрчилж болно.

**Ш.Цолмон:** Тайлан дээр иргэний нийгмээс юу хийсэн бэ гэдгийг нэмж болж байна, компаниудын зүгээс юу хийсэн гэдгийг нэмнэ, Сангийн яам талаас, ТЕГ, АМГ талаас тухайлаад юу хийсэн, жишээлбэл орон тооны ажилтантай болсон гэх мэтээр олон ажлууд байгаа, тэр болгоныг аль болох дэлгэрэнгүй оруулж болно гэж би ойлгоод байна. Ямар ч байсан та бүхэн саналаа аль болох дэлгэрэнгүй ойрын өдруудэд удаахгүй өгвөл сайн байна.

**Н.Баярсайхан:** Иргэний нийгмийн байгууллагын ажилласан талаар энэ дээр байхгүй байгаа, орон нутагт ажилласан юмнууд бас байхгүй байна. Үндэсний түвшинд хүрч ажиллаагүй, орон нутгийн түвшинд хүрч ажиллаагүй байгаа. Ажиллах зорилго, санаачилга байсан боловч ажиллаж чадаагүй гэдэг юм уу яагаад ажиллаагүй юм бэ гэдэг энэ шалтгаан тайлбараа энэ тайландаа оруулвал зүгээр юм уу. Мэдээж Монгол Улсын баталгаажуулалтын тайлангийн дагуу явж байгаа учраас талуудынхаа хийсэн гол гол ажлуудыг нь энд оруулвал бас зүгээр юм уу. Тэгвэл зүйтэй байна. Ямар ч гэсэн орон нутагтаа ажиллаж чадаагүй иргэний байгууллагын шалтгааныг оруулах нь зөв байх гэж бодож байна.

**Б.Долгор:** 2011 оны хийсэн ажлын тайлан дээр саяны саналыг тусгая. Ер нь бусад оролцогчдынхоо Санаачлагын хүрээнд хийсэн ажлын талаар товч оруулах нь зөв. Бас ажиллаж чадаагүй зүйлээ ч оруулах нь зөв. Бас дутуу хийсэн гэдэг ч юм уу цаашид анхаарах ёстой ийм ийм зүйлүүд дээр бид илүү анхаарал хандуулж ажиллана гэдэг зүйл байвал зүгээр байна. Тэгээд ажлын шугамаар оролцогчиддоо танилцуулаад Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт явуулж гэсэн саналтай байна. Ажлын албаны тайлангын хувьд Алгаа гуайн хэлсэнтэй санал нийлж байгаа байх гэж бодож байна. Ажлын албаныхан үнэхээр цөөхөн хүмүүс боломжийн ажилласан байна. Тэгэхээр Алгаа гуайн өөр санал дээр өөр санал гарахгүй байгаа учраас дэмжиж байгаа юм байна гэж ойлгоод Ажлын албаныхаа хүмүүстээ баяр хүргэе. Монгол Улсын тайлан бол Үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн та бүгдийн хийсэн ажлын тайлан шүү. Та бүгдийн маань идэвхитэй оролцоотойгоор энэ ажил амжилттай явагдаж байна. Тийм учраас та бүгдэд бас талархалаа илэрхийлээд энэхүү тайлангаа сайшаагаад явъя гэсэн саналтай байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны тайлангийн агуулгын талаар Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан санал болон ажил хэргийн шугамаар өгсөн саналыг тусган ажлын шугамаар оролцогч талуудад танилцуулж, улмаар Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газарт заасан хугацаанд хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав

**Ү.ХЭЛЭЛЦСЭН нь:** Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох талаархи урьдчилсан тайлан.

**Адам Смит Интернешнл-ийн төслийн багийн Хуульч Чулуунбаатар Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох талаархи урьдчилсан тайланг танилцуулав (Танилцуулгыг хавсаргав)**

**Б.Долгор:** Асуулт тавих хүн байна уу?

**Д.Цэрэнжав:** Гурван оронд хууль байдаг гэж хэллээ. Энэ З орны хууль чинь яг ямар нэартэй, яг ямар хууль байдаг юм бэ? Парламентаас нь баталсан ОҮИТБС-ын тухай хууль гэсэн нэартэй тийм хууль байна уу, эсхүл өөр салбартай хавсруулсан, эсхүл засаглал тал руугаа ч юм уу тийм зүйл байна уу? Энэ гурван хуулийг нэг өгүүлбэрээр хэлж өгөөч, сануулж өгөөч гэж хүсэж байна?

**Чулуунбаатар:** Норвегийн хуулийн нэр нь Норвегийн ОҮИТБС-ын тухай хууль гэсэн нэартэй. Ийм хууль байгаа. Гэхдээ энэ бол маш товчлон ердөө 2 хуудас хууль. Ерөнхийдөө бүх юмнуудыг тусгасан уу гэвэл тусгасан. Гэхдээ тухайн асуудал бүрийг нэг нэг параграф-аар оруулсан. Компанууд тайлангаа гаргаж өгөх ёстой. Засгийн газар бас тайлангаа гаргаж нэгтгэх ёстой. Ийм л гол гол зарчмуудыг тусгасан хууль байгаа. Гэхдээ энэ дээр нэг юм анхаарах хэрэгтэй. Норвеги дээр бол Монголын нөхцөл байдалтай арай өөр байна. Тэнд ерөөсөө яг олборлох үйлдвэрлэл эрхэлдэг улсын нэг л компани байна. Компанийхаа нэрийг дурдаад хуулиndaа хийгээд өгсөн. Нигери болон Либери гэсэн хоёр улс бол бас яг адилхан хуулийн нэрийн хувьд ОҮИТБС-ын тухай хууль. Либерийн хувьд ерөнхийдөө яг байгууллагынхаа бүтэц, зохион байгуулалт, эрх үүрэг талаас нь илүү оруулж өгөөд дээрээс нь нэмээд хариуцлага оруулсан байгаа. Тэр хариуцлага дотроо бол торгуулиас эхлээд тухайн компаний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах ийм хууль байгаа. Нигерийн хууль бол байгууллагын талаар оруулсан байгаа. Ямар байгууллагын статустай энийг хариуцаж явах, тэгээд тайлан гаргах тал дээр нэлээн голлоод хийсэн ийм л хуулиуд байгаа юм.

**Э.Сумьяа:** Хоёр улсын бие даасан хууль ерөнхийлөгчийн засаглалтай учраас ерөнхийлөгч нь баталсан байгаа. Түрүүчийн ажлын хэсэг энэ 2 хуулийг судалсан шүү дээ. Цолмон дээр байж байгаа. Норвегийн хууль журмаар баталгааждаг, бүх журмуудыг сайд нь баталсан байдаг.

**Чулуунбаатар:** Хуулиараа бол холбогдох дүрэм журам, хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх зүйлийг сайд батална гээд хуулиndaа заасан байдаг.

**Э.Сумьяа:** Ерөнхийдөө бол парламентаар хэлэлцээгүй хуулиуд юм.

**Б.Батболд:** Олон улсын хуулиудыг судалсан байна. Манай Монгол Улс олборлох үйлдвэрлэлийн талаар бас нэг хуулийн төсөл, үзэл баримтлал гаргасан. Тэрийг та нар судалж үзсэн юм уу?

**Чулуунбаатар:** Ер нь гадны улсын хуулиудтай 2010 оны манай боловсруулсан төслийг харьцуулаад үзэх юм бол миний хувийн зүгээс бараг энэ 2

хуулиас илүү болсон юм шиг санагдаж байгаа. Гэхдээ 2010 оны хуулийн төсөл маань Хууль зүйн яамнаас хэд хэдэн үндэслэлээр буцсан. Хамгийн гол үндэслэл бол давхардсан байсан гэсэн нэг юм байгаа. Дараа нь Засгийн газрын болон эрх бүхий байгууллагуудын эрх үүргийн талаар энэ дээр үндсэн хуульд зөрчилдсөн давтагдсан юм хийсэн байна. Тэгээд нэр томъёо, уг хэллэг, найруулга гэсэн ийм шалтгаануудаар буцаасан байгаа юм. Бид одоо ярилцаад юу гэж үзсэн бэ гэхээр давхацсан гэдэг шалтгаан бол биш юмаа гэж үзэж байгаа. Компанууд тайлангаа гаргаад одоо Санаачлагыг хэрэгжүүлж байгаа байгууллагад гаргаж өгдөг, Засгийн газрын зүгээс бас тайлан гаргаж өгөх үүрэгтэй, үүрэг функцтэй тийм юмыг хийх гээд байгаа. Тэгэхээр Хууль зүйн яамны үндэслэлээр бол ерөнхийдөө ашигт малтмалын хуулийн дагуу тайлан гаргаж өгч байгаа, энэтэй давхцсан гээд ийм л юм ярьж байгаа. Ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийг боловсруулах үндэслэл шаардлага, нийгэм эдийн засгийн үндэслэл шаардлага, хууль зүйн үндэслэл шаардлага гээд үүнийгээ маш сайн гаргаж өгөх хэрэгтэй.

**Б.Долгор:** За өөр асуулт байна уу?

**Н.Баярсайхан:** Танай төсөл хэр хугацаатай төсөл юм бэ?

**Чулуунбаатар:** Ер нь бол яг энэ хуулийн ажлын хэсгийн төсөл бол хугацаа нь их богино. Түрүү жил 14 хоногийн хугацаа байсан, дээр нь нэмэлтээр бас нэг хэд хоногийн хугацаа байгаа. Гэхдээ ер нь холбогдох хүмүүс ярилцаад цаашид энэ хуулийн төслийг аль нэг хувилбараар нь сонгосон тохиолдолд үүн дээр мэдээж оролцоод ажиллах боломжтой байх гэж бодож байна.

**Н.Баярсайхан:** Энэ төслийн үр дүнд хууль, үзэл баримтлалаа батлуулсан байх ёстой юм уу, яг ямар бүтээгдэхүүн, хэзээ гарсан байх ёстой юм бэ? Алхам яриад л, шинжилгээ хийгээд байсаар байгаад цаг хугацаа, мөнгө нь дуусаад ингээд юу ч үгүй болох гээд байх шиг байна.

**Чулуунбаатар:** Яг хуулийн төслийн гаргах ёстой бүтээгдэхүүн бол нэгдүгээрт дүн шинжилгээ хийгээд боломжит хувилбаруудыг гаргаж ирэх, хоёрдугаарт хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулна гэсэн ийм бүтээгдэхүүн байгаа. Гэхдээ яг одоо хуулийн төслийг арван хэдэн хоногийн дотор суугаад бичээд гаргана, дүгнэлт гаргана гэдэг бол хүндрэлтэй асуудал. Үзэл баримтлалыг бол боловсруулж гаргана. Одоо аль нэг сонгосон хувилбар дээр үндэслээд үзэл баримтлал, танилцуулгаа гаргана. Гаргаж өгөхийн бол ингээд албан ёсны төсөл дуусчихаж байгаа юм л даа.

**Н.Баярсайхан:** Үзэл баримтлал боловсруулах байх. Хамгийн гол нь батлуулсан байх гэсэн шалгуур байдаггүй юм уу?

**Чулуунбаатар:** Төслийн хүрээнд үзэл баримтлалыг батлуулна гэхээр ер нь хүндрэлтэй. Яагаад гэхлээр хуулийн төслийг аль нэгэн яамнаас санаачлаад явна. Яаман дээр ажлын хэсэг байгуулагдах байх. Тэнд бол ер нь хамтраад ажиллана гэсэн чиг байгаа.

**Н.Алгаа:** Одоо танай төсөлд хугацаа үлдээгүй байна тийм үү?

**Д.Болдбаатар:** Үзэл баримтлалаа хийх гэхлээр чинь ОУИТБС+ нь гээд баахан юмнууд явж байгаа шүү дээ. EITI + гээд. Эд нарыг олж харсан юм уу? Ямар бүтэцтэй, юу олж харсан юм бэ? Тэгж байж үзэл баримтлал чинь гарна биз дээ

**Чулуунбаатар:** Хуулийн хамрах хүрээ гэхээр ерөнхийдөө яг юу юу оруулах вэ гэдгээ гурван талаас EITI+ ийг одоо оруулаад явах юм уу, эсхүл эхний ээлжинд ямар ч байсан хууль гаргачихъя. Бие даасан хуулиараа 2 талаасаа тайлан гаргадаг, нэгтгэдэг, зөрүү гарсан бол зөрүүг нь арилгадаг, хууль зөрчсөн бол ямар хариуцлага тооцох, энэ механизмыг оруулъя гэсэн ерөнхий зүйл байгаа.

**Болдбаатар:** Хууль байхын ач холбогдол нь хариуцлага тооцох гэж байдаг.

**Ш.Цолмон:** Чулуунбаатар жаахан буруу яриад байна. Яг эдний даалгавар бол хуулийн төслөө УИХ-д өргөн бариад дуусч байгаа юм. Хуулийн үзэл баримтлалаа батлуулаад, тэрнийхээ үндсэн дээр хуулийн төслөө боловсруулаад, холбогдох яамдаар оруулаад, дараа нь Засгийн газрын хуралдаанд оруулаад, Засгийн газар дэмжвэл УИХ-д өргөн барина. 2012 оны 3 дугаар сар ч юм уу, 4 дүгээр сар ч юмуу, 10 дугаар сар ч юм уу, хэзээ өргөн барих нь бол тодорхойгүй Тийм л процедур байгаа. Чи өөрөө буруу яриад байна.

**Н.Алгаа:** Та нар үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулаад УИХ-д өргөн барих юм байна. Тэрнээс цаашаа лоббиг бид хийгээд, та нарт бүтээгдэхүүнээ гаргаж өгөх ёстой шүү дээ.

**Чулуунбаатар:** Ерөнхий төслийг мэдэхгүй. Би бол үзэл баримтлал боловсруулаад дуусах гэдэг өөрийн оролцоо гэрээнийхээ хүрээнд тайлбараа хийлзээ.

**Б.Долгор:** За өөр асуулт байна уу.

**Н.Алгаа:** Санал байна. Бүх төсөл дотор манайхан ингэдэг юм. Дотоодын асуудлаа удаан шийддэг, тэгээд төсөлтэй танилцаад дараа нь өөрчлөөд баахан өөчлөөд хийсэн ажлыг нь будаа болгоод хаячихдаг. Нэг ийм жишиг Монгол Улсад байгаа. Тэгэхээр би зүгээр цаг хугацаандаа, тэртээ тэргүй эдний зөвлөмж нь тусдаа хууль байх нь зүйтэй юм байна гэсэн зүйл нэгдүгээрт явж байгаа тохиолдолд эд нар ажлын хэсэг, үндэсний зөвлөлөөс шийдвэр хүлээгээд байгаа юм бол шийдвэрийг нь хурдан гаргаж өгөх ёстой юм байна. Дор хаяж ажлын хэсгийн хэмжээнд бид ингээ гэвэл эд нар цааш нь гялс хийчихмээр харагдаад байна. Мэдээж үзэл баримтлал боловсруулаад дахиад энэ ажлын хэсэгт танилцуулах байлгүй. Тэрэн дээр нь одоо хэдэн нэмэх-тэй байх вэ гэдгээ ярихаас биш, одоо бол боломжгүй. Хамгийн гол эдний олсон юм бол тусдаа хууль гаргах хэрэгтэй гэжээ. Би дотроо нэг л юм бодоод байна. Ашигт малтмалын тухай хуульд нэг заалт байгаа. Тэр бол ил тод мэдээллээ нээлттэй байлгана гэж байгаа. Тэрэн дотор олборлосон уулын чулуу ч ороод явчихмаар юм шиг юм байгаа. Энэ хууль гаргаад дараа нь маргаан үүсэх юм бол

нөгөө хоёр хууль хоёр ондоо юм шиг гараад яг маргаан үүсгэхээр зөрчилдөөн гарна. Тэгэхээр одоо та нар хуулийн төсөл хийхдээ бусад бүх хуулинд байгаа тэр нээлттэй холбоотой юмыг нь бүгдийг нь цэвэрлээд энийг гаргахгүй бол батлаад явуулчихдаг дараа нь зөрчил гардаг асуудлыг анхаараачээ гэж хэлэх гэсэн юм.

**Э.Сумьяа:** Хуулийн төслийн урьдчилсан танилцуулгын талаар түрүүчийн ажлын хэсгийн хуралдаан дээр би саналаа хэлж байсныг та бүхэн мэдэж байгаа. Энэ дагуу өчигдөр Чулуунбаатартай утсаар ярьсан. Пол Моффаттай биечлэн уулзаж 2 цаг ярилцсан. Тэрийгээ ажлын хэсэгт маргааш танилцуулна гэж бид тогтсон. Энэ танилцуулгыг үзэх юм бол хуулийн зөрчил гарах юм байхгүй. Энэ талаар би 13 үндэслэл гаргаж Полтой ярилцсан. Тэгээд энэ дээр тэр үндэслэлүүдийг тусганаа гээд Пол хэлсэн. Пол одоо угээ хэлэх байх. Энэ 13 зүйлийг би яриад яах вэ, хамгийн гол нь миний санал тавьсан ажлын хэсэгтээ хэлэх гэж байгаа зүйл бол энэ саяын Чулуунбаатарын 3 хувилбар гэдгийн 2 хувилбар нь манайд хэрэгтэй байгаа юм. Яаж ч бодсон бие даасан хууль гарвал, одоо та нар 7 дугаар үзүүлэng хараарай, бусад хуулиуд дээр байгаа зөрчилтэй олон заалт байгаа. Түрүүчийн ажлын хэсгийн хурал дээр Жигдэн гуайгаар зөвхөн тайлан гаргах хугацааны талаар слайд үзүүлсэн. Тэрийг тухайн хуулиуд дээр оруулахгүй бол нягтлан бodoх бүртгэлийн юмыг хуулийнхаа төсөл дээр хийе гэвэл Хууль зүй, дотоод хэргийн яам хэзээ ч зөвшөөрөхгүй. Манай хуулийн үзэл баримтлал бол тухайн хуулин дээр нь асуудлаар иж бүрэн зохицуулж явдаг. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхдээ бид маягт батлуулахаас эхлээд бүх л асуудлаа дандаа хуулиудаар зохицуулаад яваад байгаа. Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиар маягтаа бид нар батлуулчихаж байгаа юм. Тэгэхгүй энэ бие даасан хууль дээр маягт энэ тэр батлана гэх юм бол нөгөө хуультай давхардчихна. Энэ зүйлийг би өчигдөр ярьсан. Мөн Жигдэн гуайн хийсэн тайлан гаргах хугацааны талаарх зөрчилтэй слайдуудаа Польд өгсөн. Бие даасан хууль гаргах нь уг нь зүйтэй. Зөрчигдэж байгаа, зөрчилтэй байгаа хуулиадад заавал нэмэлт, өөрчлөлт оруулна. Тэгж байж манай хууль явна, тэхгүй бол бид түрүүн ганцхан бие даасан хууль гаргаж явж байгаад Хууль зүй, дотоод хэргийн яамыг мөргөчихсөн шүү дээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас барьж байгаа бодлого, барьж байгаа аргачлалыг өчигдөр бид Польд өгсөн. Тэгээд 4 дэх өдөр төслийн удирдах хороогоор энэ асуудлыг хэлэлцэнэ гэж тохирсон. Хоёрдугаарт бие даасан хууль байж болно. Гэхдээ бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна. Тийм учраас хуулийн судалгаа сайн хийх ёстай. Өчигдөр Чулуунбаатартай утсаар ярьсан өнөөдөр тэрийгээ ярихгүй байна. Хүлээж авахгүй байгаа юм байлгүй, хэн мэдхэв. Ер нь бол ажил, сонгон шалгаруулалтад шалгарна гэдэг бол хариуцлага байдаг юм. Сонгон шалгаруулалт бол мөнгө авах асуудал биш. Би энийг Полтой ч ярьж, дотоодын үндэсний зөвлөхүүдтэй ярина. Зөвлөх бол хариуцлага шүү, энэ сонгон шалгаруулалтад шалгарна гэдэг хариуцлага. Нөгөө тал дээр энэ хуулийг боловсруулснаар Монголд нэг чадавхи бий болж байгаа, бидэнд туслах чадавхи бий болж байгаа юм. Үүнийг бас Чулуунбаатар надтай зөвшилцсөн л дөө энийг сонирхож байгаа гэж. Төслийн тайлан, сонголтын талаар хэрхэн ажиллаж байгаагаа ажлын хэсгийнхээ хурал дээр та бүхэндээ мэдээлчихье. Өөрөөр хэлбэл та нарын араар ямар нэг юм хийгээгүй. Тайланг сайжруулахын төлөө яваад байгаа. Уулзалт болгондоо Ажлын хэсгийн ахлагчтай уулзсан, Цолмонтойгоо хоёулаа

уулзалт болгоны үр дүнг эргэж танилцуулсан. Ярих сэдвээ ерөнхий д нь танилцуулсан. Ярьсан тухайгаа ч танилцуулсан байгаа.

**Чулуунбаатар:** Сумьяа гуайн өчигдөр өгсөн саналуудыг хуулийн ажлын хэсгийн тайланд тусгана

**Д.Цэрэнжав:** Танилцуулгаас харахад хууль гарах тал руугаа үйл явц өрнөж байгаа юм байна. Янз бүрийн байр суурь сонсох хэрэгтэй гэж байна. Би бол энэ хууль гаргах хэрэггүй гэдэг байр суурьтай байна. Яагаад гэвэл яг чин үнэнийг хэлэхэд ерөөсөө энэ ОҮИТБС гэдэг чинь тэртээ тэргүй компаниуд хийх ёстой ажил, тайлагнах ёстой. Ноднин гарсан Сангийн яамны журам байна. Хандив тусламжаа хүртэл улсын төсөвт суулгаад бүртгүүлэх ёстой. Тэртээ тэргүй байх ёстой юмыг одоо ингээд тусад нь ийм юм болгоод байх шаардлагагүй. Ингэж хууль гаргана гээд ямар нэг асуудал тулгарахаар хууль гаргана гээд тэрнийхээ хойноос бөөн ажил болоод хэдэн жил яваад, хууль гарсан ч гэсэн хуулиа боловсронгуй болгоно гээд л ийм юманд явдаг хүмүүс болчлоо. Миний бодлоор энэ чинь тов тодорхой цаанаасаа бусад бүх хуулиараа хийгдэх ёстой ажлууд учраас энэ Санчаачлагч гэдэг утгаар нь магадгүй Засгийн газрын тогтоол хангалттай ч юм шиг. Бүр болохгүй бол иргэний нийгэм, бизнес уул уурхайн компаниуд, Засгийн газрын гурван талын харилцан ойлголцлын санамж бичиг ч юм уу, тохиролцоо ч юм уу ийм шугамаар явбал зүйтэй юм бишүү. Яагаад гэвэл татварын тогтолцоо, маягт энэ тэр нь цаанаа маш их асуудлтай учраас ийм хууль гарвал үргэлж зөрнө, амьдрал баян юм болохоороо. Ингээд энэ хоёрыг тохируулахын хойноос хөөцөлдсөн ийм сунжирсан ажил болох вий. Ийм учраас ямар учраас, ямар байдлаар, яагаад хууль гаргах ёстой гэдгийг шийдсэн санал асуусан байдаг юм уу? ажлын хэсгээс дүгнэлт гарсан байдаг юм уу? Ажлын хэсэг ямар статустай энийг сонсож байна? Хууль гаргах ёстой, гаргах ёсгүй гэдэг дээр харах байдлаар ажиллах ёстой байдаг юм уу, энэ нь надад ойлгомжгүй санагдаж байна. Тийм учраас би өөр байр суурь илэрхийлж байгаа юм.

**Э.Сумьяа:** Цэрэнжавын саналд хариулт хэлье. 2010 онд бид нар хуультай болъё гээд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, графикийг Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд Зоригт сайдад явуулж, яам ажлын хэсэг байгуулсан. Бид ажлын хэсгээрээ хуулийн төслөө бас хэлэлцсэн. Тэгээд энэ төсөл маань явахгүй болохоор ЕСБХБ-д хуулийн зөвлөгөө аваад явж байгаа юм.

**Б.Батболд:** Шинээр юу хийсэн юм бэ? Юу ч байхгүй байна.

**Б.Долгор:** Харин тийм. Одоо ингээд хууль гаргана гээд дүгнэлт хийж байгаа бол ямар ямар асуудлыг зохицуулах юм бэ? Наад зах нь үзэл баримтлалд орох асуудлуудаа танилцуулах ёстой. Яг ийм ийм юмыг оруулж зохицуулах учраас бид бие даасан хууль гаргах нь зөв гэж үзэж байна гэдгийгээ танилцуулах ёстой байсан. Сая тэгээд тэр нь ерөөсөө танилцагдсангүй. Тийм болохоор бид нар одоо ингээд бие даасан хууль гаргах нь зүйтэй юм байна, эсхүл гаргах шаардлагагүй юм байна гэсэн ийм дүгнэлт хийх ямар ч боломж олдохгүй байна. Тийм ч учраас жишээлбэл, сая Цэрэнжав гуай ч хэлж байх шиг байна, бас

бусад хүмүүс хэлж байна л даа тэгэхээр одоо би бол жишээлбэл энийг сонсоод одоо яг яах вэ гэдгийг, хурлаас яах вэ гэдгийг бол мэдэхгүй болчихоод байна. Та нөхөд яг тэр талаар юм хэлсэнгүй, хэлэх боломж ч үнэндээ бас алга байна. Тэгэхээр одоо яадаг билээ, мэдэхгүй болчихоод байна.

**Н.Алгаа:** Одоо тэр төслийн хүрээнд зорилго нь эрхзүйн баримт бичгийн төсөлтэй, үзэл баримтлалтай болох, тийм хугацаа байгаа, тийм зорилго боломжтой байгаа гэж би ойлгоод байна. Ямар ч тохиолдолд УИХ баталсан ч, батлаагүй ч хуулийн төсөл дээр ажиллаж, энэ үзэл баримтлал дээр. Мөнгө зарсных бүтээгдэхүүн хэрэгтэй. Бид урьд өөрсдөө бүтээгдэхүүн гаргасан, муу боловсрогдсон, эсхүл үзэл баримтлал сайн хийгээгүй ч юм уу, хуулиа буцаалаа. Тэгээд гол нь энэ нэр хүндтэй байгууллагын ажил илүү сайн бүтээгдэхүүн гарах байх гэж энэ төсөл ажиллаж байгаа гэж би бодоод байгаа. Танилцуулгыг нь сая сонсоход урьдчилсан хэсэг байлаа. Тэгэхээр үзэл баримтлал хэрэгтэй байна, хуулийн төсөл ч бас хэрэгтэй байна.

Өнөөдөр яахав, эсрэг саналтай хүмүүс байна, урд нь ажлын хэсэг хуралдаад иргэний нийгмээс маш их хүсэлт гарч байж "хэрэгтэй" гэж тохироод явсан юм. Өнөөдөр хэрэггүй гэж үзээд байгаа юм бол тийм муур хулгана шиг тоглоом хэрэггүй л гэж бодож байна. Ямар ч гэсэн үзэл баримтлал, хуулийн төсөл хоёртой үлдэх ёстой. Тэгэхгүй бол бид одоо хичээл заалгах гэж сусан биш. Зорилго нь бол бүтээгдэхүүн юм.

**Болдбаатар:** Гурван улс хуультай гээд ярилаа, тэд бас үзэл баримтлалтай биз дээ.

**Н.Алгаа:** Тэр гурван улсын хуулийг чинь ажлын хэсэг аваад Англиас орчуулаад хийсэн. Бүтээгдэхүүн хэрэгтэй. Ер нь одоо төслийн хугацаа нь байгаа юм уу, мөнгө нь хүрэх юм уу

**Э.Сумьяа:** Пол хариулна л даа

**Пол Моффат:** Өмнө нь нэг удаа хуулийн төсөл боловсруулаад, тэр нь одоо бүтээгүй буцаагдаж байсан учраас төслийн хүрээнд 2 үе шаттайгаар ажиллах шийдвэрийг бидний зүгээс гаргасан. Эхний шийдвэр нь бидний зүгээс ажлын хэсэг бие даасан хуультай байх нь зүйтэй гэсэн сонголтыг хийсэн гэсэн ойлголтыг аваагүй байсан. Эхний ээлжинд ямар ямар хувилбарууд байж болох вэ гэдгийг гаргаж ирээд ажлын хэсгээс сонголт хийлгээд эхлээд тийм хувилбарыг сонголоо гэсний дараа бүтээгдэхүүн болох хуулийн төслөө бэлтгэх ажил руугаа орох гэсэн юм гэсэн хоёр үетэй байхаар шийдсэн юм. Эхлээд ийм ийм хувилбартай байна, хувилбараа сонгочих юм бол бүтээгдэхүүн гаргахын тулд нилээд хэмжээний нүсэр ажил хийгдэх байх тиймээс эхлээд сонголтоо, хувилбараа хийчихээд хувилбараа гаргаж ирээд тэрний дараа бүтээгдэхүүнээ гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм. Өнөөдрийн хувьд бол хувилбаруудаа танилцуулж байгаа юм.

Тэгэхээр энэ удаа зөвлөхүүд ямар даалгавар авч ажилласан бэ гэхлээр бусад улс орнуудын туршлагыг судлаад яг энэ гурван хувилбар гаргаж ирээд үүнээс аль нь илүү дээр байна вэ гэдгийг бусад улс орны туршлагаар аль хувилбараар явах нь ямар үр дүнд хүргэсэн бэ гэдгийг гаргаж ирж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулаад энэнээс дараагийн алхам руугаа орох зорилт тавьсан юмаа.

Дараагийн зорих алхам юу вэ гэвэл нэгэnt ажлын хэсгээс энэ саяын танилцуулсан хувилбаруудаас аль нэгийг сонгосны дараа түүний үндэслэл, учир шалтгааныг нь сайтар тайлбарлаад сонголтын дагуу бүтээгдэхүүнээ гаргаад бүтээгдэхүүнээ санал, тайлбар, үндэслэлтэй УИХ-д уламжлуулан явуулах ийм зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Мөн Цэрэнжав гуайн саяын хэлсэн бие даасан хуультай байхын эсрэг саналын талаар бас нэг тайлбар хэлье. Яг өнөөгийн нөхцөл байдал ямар байна гэх юм бол энэ хуулиар тусгагдах асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагууд маш олон хуулиудаар тараад байрласан байгаа. Энэ нь компаниудад төдийгүй захирагааны ажлыг илүү хүндрүүлэх үр дагавартай байгаа юм. Бие даасан хуультай байх нь энэ хүндрэлтэй олон талтай тархай бутархай хуваагдсан үүрэг хариуцлагуудыг нэгтгээд ерөнхийдөө нийт үйл явцыг илүү оновчтой хялбар хэрэгжүүлэхэд дөхөм болгох ач холбогдолтой. Сумьяа даргын дурдсанаар хэрвээ бие даасан хуультай байх сонголтыг хийсэн тохиолдолд давхар нэмэлт, өөрчлөлтүүд холбогдох бусад хуулиудад хийгдээд явна. Цаашдаа ямар дэс дарааллтай явах вэ гэвэл бидний энэ тайланд оруулсан сонголтуудын талаар та бүхний зүгээс асуух асуулт, нэмэлт, тайлбар, комментийг бид сонссоны үндсэн дээр бид зөвлөмжөө эцсийн байдлаар гаргаад энэ зөвлөмжийн дагуу сонголтоо хийгээд сонголт хийгдсэний дараа бүтээгдэхүүнээ боловсруулаад тайлбар үндэслэлтэй нь хамт цаашид дараа дараагийн алхамыг шийдэж болно.

**Б.Долгор:** Төсөл хэрэгжүүлэхдээ бид нарт анхнаасаа жаахан дутагдалтай явсан тал байгаа юм. Төслийн удирдах хороо байгуулагдахаас өмнө энэ гэрээ энэ тэр хийгдээд явсан. Тэгэхээр нэгдүгээрт энэ байдлыг засах ёстой байгаа юм, Хоёрдугаарт гэвэл тусдаа хууль гаргах нь зүйтэй байна гэсэн шийдэл гаргах тийм нөхцөл бүрдээгүй байна гэж бид үзэж байна. Жишээ нь тэр тусдаа хуулин дээр ямар ямар асуудлыг зохицуулах вэ гэдэг нь огт байхгүй учраас яг ийм байх нь ээ гэж авч үзэх арга байхгүй. Урд нь ярилцаж хэлэлцээд ингэсэн. Гэхдээ энэ төслөөр хэрэгжүүлэх ажил бол тусдаа ажил юм. Танаас нэг лавлах зүйл байна. Үнэхээр энэ ажил хуульчтай хийсэн гэрээний биелэлт яг болсон гэж та үзэж байгаа юм уу, одоо жишээ нь хувилбар дэвшүүлэх ёстой гэж яриад байна, тэгж гэрээ хийсэн юм шиг байна. Хувилбар дэвшүүлэх ийм боломжтой тайлан гаргалаа гэж та үзэж байна уу гэж би танаас лавлах гээд байна.

**Пол Моффат:** Энэ тайлангийн хувьд бие даасан тусдаа хуультай байна гэхэд ямар ямар хуулиудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах вэ гэдгийг тодорхой зааж өгсөн. Мөн боломжит хувилбаруудыг гаргаж ирсэн. Энэ тайланг хангалттай сайн тайлан гэж бид тодорхой хэмжээгээр дүгнэж байгаа. Гэхдээ энэ тайланг сайжруулах нэмэлт мэдээллийг оруулж болно. Сумьяа гуайн хэлсэн шүүмжлэлийг

оруулаад тэр утгаараа одоо хийгдсэн болж байнаа гэж үзэж байна. Ямар нэг тухайлсан санал хүсэлт санал гишүүдэд байвал тэр талаар нэмэлт ажил хийж болж байна. Мөн юу нэмж оруулж болох вэ гэвэл Санаачлагын зохион байгуулалтын бүтцийн талаар нэмж оруулж болох юм. Энэ нь тайлбар дээрээ хэрхэн зохион байгуулагдсан нийгэмд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэсэн талаас тайландаа оруулж болох талтай. Бас хатагтай Долгорын хэлсэнчлэн хэрэв бие даасан хуультай байх юм бол бие даасан хуулийн агуулга юу байх вэ гэдгийг энд оруулж өгөх юм. Мөн уг бүтээгдэхүүнд гишүүдийн зүгээс ямар ямар асуудлуудыг нэмж оруулвал зүйтэй вэ гэж үзэж байгаа асуудлуудаа бидэнд ирүүлэх юм бол энэ тайланг сайжруулсан хувилбарт тусгаж болно. Ажлын хэсэгт сонголтуудаас, хувилбаруудаас сонголтоо хийхэд шаардлагатай нэмэлт ямар ч мэдээллийг оруулахад бэлэн байна.

**Н.Алгаа:** Хэрэв ажлын хэсгээс тусдаа хууль байна гээд шийдвэр гарвал үзэл баримтлал, хуулийн төсөл хэдийд бэлэн болох вэ?

**Пол Моффат:** Нэгэнт ажлын хэсгээс шийдвэр гаргавал бүтээгдэхүүн гаргахад нэг их удахгүй, үндэслэлийг маш ойрын хугацаанд гаргачихаж болно. Хуулийн төслийг 2-3 долоо хоногт гаргана. Юунд их цаг зарцуулах вэ гэвэл Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулахад нэлээн удах бол уу гэж бодож байна. бүтээгдэхүүн гаргах явцад хуулийн төслийг боловсруулахад гишүүдийн саналыг бас авна.

**Н.Алгаа:** Ойлгомжгүй юм гараад байна. Төслийн эцсийн үр дүн бол үзэл баримтлал, хуулийн төсөл. Энэ ажил бол хамгийн жижиг ажил. Хамгийн гол үр дүн нь цаана нь байгаа. Эцсийн хариулт бол бүтээгдэхүүн. Тэгэхээр бүтээгдэхүүн гараагүй байхад бид наана нь төслийн ажилд оролцоод ажилд нь саад учруулах шаардлага байна уу Эд нар үзэл баримтлалыг эхлээд батлуулах ёстой гэсэн манай тэр дүрмээр явах гээд үзэл баримтлалыг батлахгүй бол хууль нь гарахгүй. Миний бодлоор үзэл баримтлал, хуулийн төслийг хамтад боловсруулаад тэгээд энд нь, үзээд хууль зүйн яаманд бид эд нартай хамт лобби хийгээд хуулийг нь гаргуулах ёстой.

**Бямбадагва:** Хуулийн төслийг явуулах л хэрэгтэй

**Б.Долгор:** Төслийн хүн маань энэ саяын хийсэн тайланг болсон гэж үзэж байгаа юм байна. Яг бид нарын хувьд миний хувьд ерөөсөө болоогүй гэж гэж үзэж байна. Цэрэнжав гуайн ярьж байгаа нь үнэн. Үнэхээр хууль гаргах ёстой гэж үзэж байгаа бол ямар учраас, ямар зохицуулалтууд хийх гэж байгаа учраас хууль гаргах гээд байгаа юм бэ гэсэн юмаа гаргаж ирж танилцуулсан нөхцөлд бид тийм шийдэлд хүрэх бололцоотой. Өнөөдөр ерөөсөө ямар ч тийм шийдэлд хүрэх бололцоо гарсангүй, гарахгүй байна. Тийм учраас энэ хийх ёстой юмаа хийгээд юуны өмнө Төслийн удирдах хороон дээр танилцуулах хэрэгтэй байна. Төслийн удирдах хороон дээр танилцуулаад тэгээд үнэхээр энэ юмаа хийсэн гэж үзэж байгаа бол бид хийсэн гэдгээр нь хүлээж авъя. Хийж чадаагүй гэж үзэж байвал бид одоо өөр юм ярих хэрэгтэй болох байх. Тийм л шийд гаргая. Өнөөдөр ингэнэ, тэгнэ гэсэн шийд гаргах арга үнэндээ алга. Тэгээд та бүгдийн хэлсэнчлэн үнэхээр хууль гаргах

хэрэгтэй юм бол үзэл баримтлалаа яаралтай батлаад хуулийнхаа төслийг үндсэндээ хамт боловсруулаад явж байх ёстой. Өнөөдөр шийдвэр гаргах арга алга. Эхний ээлжинд Төслийн удирдах хороон дээр асуудлаа саяны өнөөдрийн гаргасан хүмүүсийн санал оноог тусгаад тэгээд удирдах хороон дээр эхний ээлжинд яриад дараа нь хэрэв ажлын хэсэгт оруулах тийм нөхцөл боломж бурдэх юм бол ажлын хэсэг дээр оруулъя гэсэн ийм л шийд гаргаж байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн байдлыг боловсронгуй болгох талаархи урьдчилсан тайланг хэлэлцээд Ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусгаж танилцуулахыг төслийн багт үүрэг болгов.

Танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
Ажлын хэсгийн ахлагч

Б.ДОЛГОР

Хөтөлсөн:

Ажлын албаны харилцаа, мэдээллийн мэргэжилтэн

С.БАТБАЯР